



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 18 сарын 25 өдөр

Дугаар 124

Номгон

Хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “в”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2019 оны А/206 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсгийн Орон нутгийн өмчийн байгууллагуудад хийсэн үндсэн хөрөнгийн үзлэг тооллогоор илрүүлсэн бүртгэлд тусгаагүй 12 нэр төрлийн 8 889 490 /Найман сая найман зуун наян есөн мянга дөрвөн зуун ерэн/ төгрөгийн өртөг бүхий хөрөнгийн эзэмшигчийг хавсралтаар тогтоож, байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэсүгэй.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Хөрөнгийг бүртгэх ажлыг тухайн байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг 2020 оны 01 дүгээр сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

1190713

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны
өдрийн 124 дүгээр тогтоолын хавсралт

ХӨРӨНГИЙН ТООЛЛОГООР ИЛЭРСЭН БҮРТГЭЛГҮЙ ХӨРӨНГӨД ЭЗЭМШИГЧ ТОГТООСОН ЖАГСААЛТ

№	Сум	Эзэмшигчээр тогтоогдсон байгууллагын нэр	Хэрэгжүүлсэн төслийн нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ, төг	Нийт үнэ, төг	Ашиглалтад орсон огноо	Хөрөнгийн эх үүсвэр
1	Баянхонгор сум	Номгон сургууль	Ус цэвэршүүлэгч	2	930000	1860000	2019	Дэлхийн зөн ОУБ өгсөн падаан ирээгүй
2	Бууцагаан сум	ЭМТ	Принтер	1	350000	350000	2017.01.01	Хандиваар ирсэн
3	Бууцагаан сум	ЭМТ	Принтер	1	250000	250000	2016.01.01	Хандиваар ирсэн
4	Бууцагаан сум	ЭМТ	Төмөр ор	5	150000	750000	2017.01.01	Хандиваар ирсэн
5	Баянцагаан	Сургууль	Телевизор 60	1	999990	999990	2018.12.31	Эцэг эхийн хандиваар өгсөн
6	Баянцагаан	Сургууль	Телевизор 55	2	849900	1699800	2018.12.31	Эцэг эхийн хандиваар өгсөн
7	Баянцагаан	Сургууль	Телевизор 42	3	659900	1979700	2017.12.31	Эцэг эхийн хандиваар өгсөн
8	Галуут сум	Сургууль	Телевизор	1	380 000	380000	2018	Тамгын газрын хөрөнгийн санхүүжилтээр хийгдсэн.
9	Галуут сум	Сургууль	Утастай мик	1	210 000	210000	2018	Тамгын газрын хөрөнгийн санхүүжилтээр хийгдсэн.
10	Галуут сум	Сургууль	Микний хөл	1	130 000	130000	2018	Тамгын газрын хөрөнгийн санхүүжилтээр хийгдсэн.
11	Галуут сум	Сургууль	Диско гэрэл	1	160 000	160000	2018	Тамгын газрын хөрөнгийн санхүүжилтээр хийгдсэн.
12	Галуут сум	Сургууль	Зайны мик	1	120 000	120000	2018	Тамгын газрын хөрөнгийн санхүүжилтээр хийгдсэн.
						8 889 490,00		

000